

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/;
- Тухайн орон тоонд шилжин ажиллахыг хүссэн өргөдөл.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 10 сарын 31-ний өдрийн 09:00 цагаас 2023 оны 11 сарын 06-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: manjil@burtgel.gov.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 11320219, 80088299 /ажлын цагаар/

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний улсын бүртгэгч /Гурванзагал суманд ажиллах/	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Дээд	-Эрх зүй; -Эдийн засаг; -Нягтлан бодох бүртгэл; -Бизнесийн удирдлага; -Хэл эзэмшихүй; -Математик статистик; -Хүн ам зүй;	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
2	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний улсын бүртгэгч /Матад суманд ажиллах/	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Дээд	-Эрх зүй; -Эдийн засаг; -Нягтлан бодох бүртгэл; -Бизнесийн удирдлага; -Хэл эзэмшихүй; -Математик статистик; -Хүн ам зүй;	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
3	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Дээд	Эрх зүй	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
4	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний улсын бүртгэгч /Малчин суманд ажиллах/	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Дээд	-Эрх зүй; -Эдийн засаг; -Нягтлан бодох бүртгэл; -Бизнесийн удирдлага; -Хэл эзэмшихүй; -Математик статистик; -Хүн ам зүй;	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.